

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ, ТЭМДЭГЛЭЛЭЭР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

*/Төрийн байгуулалтын байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, танилцуулгыг Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр гаргасан болно. Мөн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийг тус шинжилгээний дүнд үндэслэн хяналтаас хасахаар хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	99	427
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1
3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй байна.

2.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 5 хуулийн 30 хэсэг, заалт мэдээллийн сангийн хяналтад байгаагаас 2019 оны жилийн эцсийн байдлаар 4 хуулийн 14 хэсэг, заалт буюу 46.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 2 хуулийн 16 хэсэг, заалт буюу 53.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 4 хуулийн 14 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 4 хуулийн 13 хэсэг, заалт үнэлэх боломжгүй, 1 хуулийн 1 заалт хэрэгжих шатанд байна.

	Хууль	Хэсэг, заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	5	30	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	3	13	43.3
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	-	-	0
- хэрэгжих шатанд	1	1	7.1
- хэрэгжилт хангалтгүй	-	-	0
- хэрэгжээгүй	-	-	0
- үнэлэх боломжгүй	4	13	92.9

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан дараах 2 хуулийн 16 хэсэг, заалтын хэрэгжилтийг 2017, 2018 он болон 2019 оны эхний хагас жилд ирүүлээгүй бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Үүнд:

	Хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1.	Төрийн болон албаны нууцын тухай /2016.12.01/	19.6 дахь заалт;
2.	Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ /2017.12.07/	24.1, 24.2, 40.1, 40.2, 43.5, 44.5, 48.9, 53.2, 54.2, 55.2, 57.8, 60.1, 60.3, 61.2, 63.2 дахь заалт;

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг давтан ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг давтан ирүүлсэн	24	53
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 7 тогтоолын 9 заалт мэдээллийн сангийн хяналтад байна. Үүнээс 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын 4 тогтоолын 4 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс хяналтад байгаа нь 3 тогтоолын 3 заалт буюу 33.3 хувь, давхардсан тоогоор 5 тогтоолын 6 заалт буюу 66.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 1 тогтоолын 1 заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	7	9	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	3	3	33.3
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	1	1	33.3
- Хэрэгжих шатанд	1	1	33.3
- Хэрэгжилт хангалтгүй	1	1	33.3
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	-	-	-

3.3. Мэдээнд гарсан зөрчил

ЗГХЭГ-аас ирүүлсэн УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн багагүй хувь нь өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтаас хасагдсан заалт байна. Сүүлийн 3 удаагийн хэрэгжилтийн мэдээний хяналтад байгаа заалтууд:

- 2018 оны жилийн эцсийн мэдээнд 54 тогтоолын 119 заалтын хэрэгжилт ирүүлснээс хяналтад байгаа нь 33 тогтоолын 83 заалт;
- 2019 оны эхний хагас жилийн мэдээнд 41 тогтоолын 85 заалтын хэрэгжилт ирүүлснээс хяналтад байгаа нь 20 тогтоолын 49 заалт;
- 2019 оны жилийн эцсийн мэдээнд 55 тогтоолын 151 заалтын хэрэгжилт ирүүлснээс хяналтад байгаа нь 38 тогтоолын 118 заалт тус тус байна.

2/ Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Улсын Их Хурлын 5 тогтоолын 6 заалт:

	Тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй заалт
1.	Нийтийн сонсголын тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2015.07.08 №72/	1 дэх заалт;
2.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2015.11.26 №105/	1.2 дахь заалт;
3.	Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай /2016.08.30 №29/	1.3 дахь заалт;
4.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /2016.09.09 №45/	2.2 дахь заалт;
5.	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2018.02.01 №15/	1, 2 дахь заалт.

ДӨРӨВ. БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтад байх заалтууд байна. Давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420
	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

4.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Төрийн байгуулалтын байнгын хорооны 4 тогтоолын 27 заалт мэдээллийн сангийн хяналтад байгаагаас 2019 оны жилийн эцсийн байдлаар 1 тогтоолын 4 заалт буюу 14.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 4 тогтоолын 23 заалт буюу 85.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 1 тогтоолын 4 заалтаас давхардсан тоогоор 1 тогтоолын 2 заалт бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 2 заалт хэрэгжих шатанд байгаа ба хэрэгжээгүй болон үнэлэх боломжгүй заалт байхгүй.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

	ТББХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	4	27	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	1	4	14.8
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	1	2	50.0
- Хэрэгжих шатанд	1	2	50.0
- Хэрэгжилт хангалтгүй	-	-	-
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	-	-	-

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн нийт 4 тогтоолын 27 заалтаас 1 тогтоолын 4 заалт буюу 14.8 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь хангалтгүй байна. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй 2016 оны 1, 2018 оны 2, 2019 оны 1 тогтоол байна. Үүнд:

	Тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй заалт
1.	Чиглэл өгөх тухай /2016.12.27 №07/	1, 2, 3 дахь заалт;
2.	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл /2018.05.01 №07/	2, 7, 8, 9, 10, 11, 12 дахь заалт;
3.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Засгийн газарт чиглэл өгсөн хуралдааны тэмдэглэл /2018.05.15 №09/	2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6 дахь заалт;
4.	Төрийн албаны зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл /2019.05.15 №13/	1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасах 1 хуулийн 1 заалт, УИХ-ын 1 тогтоолын 1 заалт, Байнгын хорооны 1 тэмдэглэлийн 2 заалт байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн нийт хууль тогтоомжийн хэрэгжилт өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй сайн буюу дунджаар 64.3 хувийн мэдээг ирүүлсэн хэдий ч тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтад байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй ирсэн байна. Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах ирүүлээгүй хууль тогтоомж:

- 5 хуулийн 30 хэсэг, заалтаас 2 хуулийн 17 хэсэг, заалт буюу 56.7 хувийн;
- Улсын Их Хурлын 7 тогтоолын 9 заалтаас 5 тогтоолын 6 заалт буюу 66.7 хувийн;
- Байнгын хорооны 4 тогтоолын 27 заалтаас 4 тогтоолын 23 заалт буюу 85.2 хувийн хэрэгжилтийн мэдээг тус тус ирүүлээгүй болно.

2/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хугацаа хоцруулж ирүүлдэг дутагдал давтагдсаар байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
		<p>30.2. Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.</p> <p><i>/24.1.1.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;/</i> <i>/24.1.2.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;/</i></p>	<p>Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга 2017.12.07/ хуульд уг заалт тусгагдсан тул хасах саналтай байна.</p>
Нийт 1 хуулийн 1 хэсэг			

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ**

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт /ЗГХЭГ-аас ирүүлсэн/
1.	<p align="center">Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2016.09.09 №45</p>	<p>2.1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны байдлаар нэгтгэн гаргаж, Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн болно.</p>
<p align="center">Нийт 1 тогтоолын 1 заалт</p>			

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1.	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018.05.01 №07	<p>1. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос хэрэгжүүлэхтэй холбогдуулан дагалдан гарах бусад хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулахад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдууд, Төрийн албаны зөвлөл ажлын нарийвчилсан төлөвлөгөө, график гарган ажиллаж, дүрэм, журмуудаар хэлэлцүүлэг зохион байгуулах;</p> <p>6. Хүнд суртал гаргадаг, авлига авдаг, ёс зүйн зөрчилтэй албан хаагчдыг 2019 оны 1 сарын 1-нээс өмнө ёс зүйн болон мэргэжлийн аттестатчилал явуулж, мэдлэг, боловсрол, чадварын шалгалт авч, энэ талаар шаардлагатай тохиолдолд Засгийн газар,</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос хэрэгжүүлэхтэй холбогдуулан дагалдан гарах 47 дүрэм, журамд холбогдох саналыг өгч, хэлэлцүүлэгт оролцож ажилласан. Тухайлбал: “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д санал өгөх тухай 83 тоот албан бичигт 03/641, “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д 05/1718, “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөнд оролцох тухай” 03/4761 тоотор, “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын төсөлд цахимаар тус тус санал өгсөн. Төрийн албаны зөвлөлөөс 2019.03.20-ны өдөр гишүүн С.Цэдэндамба ахлан ТАЗ-өөс баталсан журмуудын талаарх сургалт, 2019.05.29-ний өдөр гишүүн Д.Зүмбэрэлхам ахлан Хуулийн хэлтсийн дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтнүүдэд зориулсан арга зүйн сургалтад, 2019.12.09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан Нэгдсэн сургалт, 2019.12.11-ний өдрийн Салбар зөвлөлийн сургалт-хэлэлцүүлэгт холбогдох албан тушаалтан оролцсон.</p> <p>Үүний үр дүнд төрийн албанд иргэнийг мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлан албан тушаалд томилох, шатлан дэвшүүлэх, сэлгэх, шилжүүлэн ажиллах боломжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Төрийн албаны тухай шинэ хуулийг сурталчлах зорилгоор ЭМЯ-аас 16 заалт бүхий ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан. Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуулийг хавтаслан ном болгон хэвлүүлж, 2019 оны 1 дүгээр улиралд яамны албан хаагчдаар судлуулсан. Төрийн албан хаагч мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог байх нөхцлийг бүрэн хангах зорилгоор Эрүүл мэндийн яамны Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах саналын хуудсыг боловсруулж, яамны албан хаагчдаас санал авах ажлыг зохион байгуулан саналыг нэгтгэж, Төрийн нарийн</p>

	<p>Улсын Их Хуралд асуудал оруулж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>бичгийн даргын 2019 оны “Ёс зүйн зөвлөл байгуулах тухай” А/117 дугаартай тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн 2019 оны тайланг нэгтгэн Төрийн албаны зөвлөлд 2019 оны 5/5742 албан тоотоор хүргүүлсэн.</p> <p>2019 оны байдлаар Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “сануулах сахилгын шийтгэл”-ийг 2, “албан тушаалын цалингийн хэмжээг 1 сар хүртэл хугацаагаар 30% бууруулах сахилгын шийтгэл”-ийг 1, “төрийн албанаас халах сахилгын шийтгэл”-ийг 1 албан тушаалтанд тус тус ногдуулж, мэдээллийг Төрийн албаны зөвлөлд 2019 оны 2/3064 албан тоотоор хүргүүлсэн. /Үүнд: удирдах албан тушаалтан-1, гүйцэтгэх албан тушаалтан-3/</p> <p>ЭМЯ-ны харъяа байгууллагуудын нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, санал солилцох чиглэлээр батлагдсан удирдамжийн дагуу СЭМҮТ, НЭМҮТ, УХТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ХТС, ЭМХТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХТС, ГССҮТ, ГҮТ, АӨСҮТ-үүдэд ажиллаж, санал бодлоо солилцлоо. Дээрх удирдамжийн дагуу Булган, Дархан, Сэлэнгэ, Орхон аймгуудын Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төвд албан томилолтоор ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шинээр батлагдсан хууль эрх зүйн талаар мэдээлэл хийх ажлыг 2019.06.20-ны өдрөөс 23-ны өдрийн хооронд зохион байгуулж санал солилцлоо.</p> <p>Харъяа байгууллагуудын авлигын асуудал хариуцсан ЭБАТ-уудтай уулзаж, хамтарсан баг болж ажиллахаар тохиролцож, хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар ярилцаж, санал бодлоо солилцлоо. Эрүүл мэндийн яамны харъяа Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, захирал нарт Авлигатай тэмцэх газрын 2019.06.14-ний өдрийн 01/4939 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг 1а/2942 тоот албан бичгээр мэдэгдлээ.</p>
<p>Нийт 1 тогтоолын 2 заалт</p>		

Танилцуулга бэлтгэсэн ХШҮХ-ийн референт К.Пүрэвсүрэн